

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Булган сумын Ерөнхий боловсролын дунд сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ХОА-2022/89/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Улаанбаатар хот

2023 он

Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар

Утас: 70433061

Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn

Аудитын менежер: А.Цэцэгсүрэн

Утас: 70432545

Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn

Эл Би Альфа Экспэйншин аудит ХХК-ны

Аудитор: Г. Баясгалан

Утас: 95438030

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	12
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	15
4.1 Ерөнхий зүйл.....	15
4.2 Материаллаг байдал.....	15
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	15
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	15
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	16
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	16
5.1 Албан шаардлага	16
6. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ	17

Товчилсонүгийнжагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
СТА	Санхүүгийн Тайлангийн Аудит
НА	Нотлох Ажил
ТШЗ	Төсвийн Шууд Захирагч



**ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

БУЛГАН СУМЫН НЭГДҮГЭЭР
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
С. БАЯРСАЙХАН ТАНАА

2023.02.20 № 2/64
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.9.1-д заасны дагуу Булган сумын нэгдүгээр сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Булган сумын нэгдүгээр сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Боловсролын салбар төсвийн шинэчлэлийн хүрээнд сургуулийн санхүүгийн эрх мэдэл, хувьсах зардал, сургуулийн бүтэц, хэв шинжийн шинэчлэл, сургалтын чанарт суурилсан цалин урамшууллын тогтолцоог бий болгосон байна.

Багш нарын цалинг ТҮ-5 ангиллаар олгосон, хувьсах зардлын тухайд багшийн эрүүл мэндийн үйлчилгээ, дата хэрэглээний зардал, хичээл практикийн зардал, багшийн мэргэжлийн тасралтгүй хөгжлийн зардлыг тусгаж, төлөвлөх, зарцуулах аргачлалыг Засгийн газрын 2022 оны 91 дугаар тогтоолоор баталж мөрдсөн байна.

Аудитын гол асуудал

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

Бусад асуудлын хэсэг

Тус сургууль нь 2022 онд нийт 1500 хүүхэд сургах хүчин чадалтайгаас гүйцэтгэлээр 1173 хүүхдийг бага дунд боловсролд хамруулж биелэлт 78.2 хувьтай байна.

021020182

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.


Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой. "

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ХҮНДЭТГЭСЭН: ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:  Х.БОЛДБААТАР



2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	101,731,938.40	70,968,388.40
33	АВЛАГА	13,900,000.00	00.00
335	Бусад авлага	13,900,000.00	00.00
3351	Байгууллагаас авах авлага	13,000,000.00	00.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	900,000.00	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	87,831,938.40	70,968,388.40
351	Түүхий эд материал	38,400.00	379,100.00
35130	Эм боох материал	38,400.00	379,100.00
354	Хангамжийн материал	87,793,538.40	70,589,288.40
35410	Бичиг хэргийн материал	400,000.00	400,000.00
35420	Аж ахуйн материал	47,524,338.40	47,642,338.40
35440	Түлш, шатах тослох материал	35,020,000.00	15,400,000.00
35460	Хүнсний материал	4,779,200.00	7,076,950.00
35470	Бусад хангамжийн материал	70,000.00	70,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	3,022,199,011.20	3,096,663,619.96
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,022,199,011.20	3,096,663,619.96
392	Биет хөрөнгө	2,975,199,011.20	3,049,663,619.96
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,972,873,699.00	2,972,873,699.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-221,866,584.00	-272,598,524.72
39203	Авто-тээврийн хэрэгсэл	23,500,000.00	23,500,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-23,500,000.00	-23,500,000.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	409,761,686.80	518,619,886.80
39206	Хуримтлагдсан элэгдэл	-372,668,726.22	-381,897,420.18
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	238,391,618.16	247,021,618.16
39208	Хуримтлагдсан элэгдэл	-135,845,525.00	-162,460,216.21
39214	Бусад үндсэн хөрөнгө	22,750,000.00	62,750,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-16,081,249.65	-18,606,250.00
39217	Ном	77,884,092.11	83,960,827.11
393	Биет бус хөрөнгө	47,000,000.00	47,000,000.00
39301	Програм хангамж	275,000.00	275,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-275,000.00	-275,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	47,000,000.00	47,000,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	3,123,930,949.60	3,167,632,008.36
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	10,421,500.75	18,521,063.19
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	10,421,500.75	18,521,063.19
413	Өглөг	10,421,500.75	18,521,063.19
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	10,421,500.75	12,348,429.19

4136	Бусад өглөг	00.00	6,172,634.00
41361	Байгууллагад төлөх өглөг	00.00	6,172,634.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	3,113,509,448.85	3,149,110,945.17
51	Засгийн газрын хувь оролцоо	3,113,509,448.85	3,149,110,945.17
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	699,055,330.28	699,055,330.28
51101	Өмч: - төрийн	699,055,330.28	699,055,330.28
512	Хуримтлагдсан үр дүн	1,149,220,207.93	1,184,821,704.25
51210	Өмнөх үеийн үр дүн	1,149,220,207.93	1,149,220,207.93
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	35,601,496.32
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,265,233,910.64	1,265,233,910.64
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	3,123,930,949.60	3,167,632,008.36

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,296,733,256.43	2,230,195,815.20
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,578,610,486.43	71,005,035.00
120	Нийтлэг татварын бус орлого	1,578,610,486.43	71,005,035.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,578,610,486.43	71,005,035.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	600,000.00	00.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	15,089,430.00	3,390,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	1,562,921,056.43	67,615,035.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	148,783,670.00	189,275,980.20
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,569,339,100.00	1,969,914,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	62,363,353.00	6,148,500.00
131102	Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл	10,600,000.00	00.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	49,694,420.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,068,933.00	6,148,500.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	86,355,200.00	182,980,752.20

132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	86,355,200.00	182,980,752.20
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	65,117.00	146,728.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	65,117.00	146,728.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,805,722,404.56	2,194,594,318.88
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,805,722,404.56	2,194,594,318.88
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,684,778,135.50	2,063,961,810.88
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,281,392,308.06	1,533,694,932.21
210101	Үндсэн цалин	1,163,607,337.74	1,530,064,064.00
210102	Нэмэгдэл	117,784,970.32	3,630,868.21
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	166,533,996.63	190,687,657.23
210201	Тэтгэврийн даатгал	140,639,138.42	190,687,657.23
210202	Тэтгэмжийн даатгал	25,894,858.21	00.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	66,346,147.00	103,371,775.20
210301	Гэрэл, цахилгаан	9,812,922.00	6,181,925.20
210302	Түлш, халаалт	55,858,225.00	97,189,850.00
210303	Цэвэр, бохир ус	675,000.00	00.00
2104	Хангамж, бараа материалын зардал	9,339,700.00	00.00
210401	Бичиг хэрэг	1,055,000.00	00.00
210402	Тээвэр, шатахуун	4,864,000.00	00.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	951,900.00	00.00
210404	Ном, хэвлэл	453,400.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	453,700.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,561,700.00	00.00
2105	Нормативт зардал	57,200,376.00	69,116,150.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	3,684,600.00	31,400.00
210502	Хоол, хүнс	50,455,226.00	69,084,750.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,060,550.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,528,810.00	1,889,700.00
210604	Урсгал засвар	2,528,810.00	1,889,700.00
2107	Томилолт, зочны зардал	430,000.00	00.00
210702	Дотоод албан томилолт	430,000.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,730,578.00	10,485,200.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,722,578.00	6,148,500.00

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,008,000.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	4,336,700.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	95,276,219.81	154,716,396.24
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	602,777.00	42,710,510.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,925,000.00	22,905,560.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	86,748,442.81	89,100,326.24
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	120,944,269.06	130,632,508.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	87,453,637.00	116,332,228.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	65,117.00	146,728.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	37,694,100.00	116,185,500.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	49,694,420.00	00.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	32,087,698.06	14,300,280.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	32,087,698.06	14,300,280.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,402,934.00	00.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,402,934.00	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	1,491,010,851.87	35,601,496.32
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	1,491,010,851.87	35,601,496.32

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/Төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	662,055,330.28	885,291,362.04	1,324,564,763.62	2,871,911,455.94
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	662,055,330.28	885,291,362.04	1,324,564,763.62	2,871,911,455.94
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	21,241,191.67	21,241,191.67
C08	2021 оны 12-р сарын 31-	699,055,330.28	1,265,233,910.64	1,149,220,207.93	3,113,509,448.85

	нээрх үлдэгдэл				
D01	2022 оны 12- р сарын 31- нээрх үлдэгдэл	699,055,330.28	1,265,233,910.64	1,149,220,207.93	3,113,509,448.85
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	699,055,330.28	1,265,233,910.64	1,149,220,207.93	3,113,509,448.85
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	35,601,496.32	35,601,496.32
D09	2022 оны 12- р сарын 31- нээрх үлдэгдэл	699,055,330.28	1,265,233,910.64	1,184,821,704.25	3,149,110,945.17

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,733,812,200.00	2,162,580,780.20
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	15,689,430.00	3,390,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	15,689,430.00	3,390,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	15,689,430.00	3,390,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	600,000.00	00.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	15,089,430.00	3,390,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,718,122,770.00	2,159,190,780.20
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,569,339,100.00	1,969,914,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	62,363,353.00	6,148,500.00
131102	Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл	10,600,000.00	00.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	49,694,420.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,068,933.00	6,148,500.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	86,355,200.00	182,980,752.20

132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	86,355,200.00	182,980,752.20
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	65,117.00	146,728.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	65,117.00	146,728.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,733,812,200.00	2,162,580,780.20
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,733,812,200.00	2,162,580,780.20
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,612,867,930.94	2,031,948,272.20
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,265,921,703.94	1,524,227,577.00
210101	Үндсэн цалин	874,319,697.77	1,082,183,858.96
210102	Нэмэгдэл	323,549,855.62	368,500,193.04
210104	Урамшуулал	68,052,150.55	73,543,525.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	172,381,500.00	191,168,200.00
210201	Тэтгэврийн даатгал	121,305,600.00	130,146,100.00
210202	Тэтгэмжийн даатгал	12,769,000.00	15,127,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	10,215,100.00	12,210,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,553,800.00	3,062,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	25,538,000.00	30,622,600.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	83,103,366.00	84,551,775.20
210301	Гэрэл, цахилгаан	9,812,922.00	6,181,925.20
210302	Түлш, халаалт	72,398,000.00	77,569,850.00
210303	Цэвэр, бохир ус	892,444.00	800,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	9,094,033.00	00.00
210401	Бичиг хэрэг	1,524,133.00	00.00
210402	Тээвэр, шатахуун	3,762,600.00	00.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	937,300.00	00.00
210404	Ном, хэвлэл	539,300.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	456,700.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,874,000.00	00.00
2105	Нормативт зардал	41,345,350.00	69,815,500.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,145,000.00	00.00
210502	Хоол, хүнс	36,662,750.00	69,815,500.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,537,600.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,964,400.00	1,848,900.00
210604	Урсгал засвар	6,964,400.00	1,848,900.00
2107	Томилот, зочны зардал	457,100.00	00.00

210702	Дотоод албан томилолт	457,100.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12,680,578.00	20,395,200.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	11,672,578.00	6,148,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,008,000.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	14,246,700.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	20,919,900.00	139,941,120.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	13,600,000.00	117,217,870.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,319,900.00	22,723,250.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	120,944,269.06	130,632,508.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	87,453,637.00	116,332,228.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	65,117.00	146,728.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	37,694,100.00	116,185,500.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	49,694,420.00	00.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	32,087,698.06	14,300,280.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	32,087,698.06	14,300,280.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,402,934.00	00.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,402,934.00	00.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/Төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,175,122,405.00	2,147,980,500.20
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,175,122,405.00	2,147,980,500.20
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,031,648,272.20	2,031,648,272.20
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,524,227,577.00	1,524,227,577.00
210101	Үндсэн цалин	1,082,183,858.96	1,082,183,858.96
210102	Нэмэгдэл	368,500,193.04	368,500,193.04

210104	Урамшуулал	73,543,525.00	73,543,525.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	191,168,200.00	191,168,200.00
210201	Тэтгэврийн даатгал	130,146,100.00	130,146,100.00
210202	Тэтгэмжийн даатгал	15,127,000.00	15,127,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	12,210,400.00	12,210,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	3,062,100.00	3,062,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	30,622,600.00	30,622,600.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	97,393,400.00	84,551,775.20
210301	Гэрэл, цахилгаан	10,743,400.00	6,181,925.20
210302	Түлш, халаалт	85,850,000.00	77,569,850.00
210303	Цэвэр, бохир ус	800,000.00	800,000.00
2105	Нормативт зардал	76,398,800.00	69,815,500.00
210502	Хоол, хүнс	76,398,800.00	69,815,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,848,900.00	1,848,900.00
210604	Урсгал засвар	1,848,900.00	1,848,900.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	20,395,200.00	20,395,200.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,148,500.00	6,148,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	14,246,700.00	14,246,700.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	139,641,120.00	139,641,120.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	116,917,870.00	116,917,870.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	22,723,250.00	22,723,250.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	124,049,208.00	116,332,228.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	124,049,208.00	116,332,228.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	146,728.00	146,728.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	123,902,480.00	116,185,500.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,182,713,424.00	2,182,713,424.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,969,914,800.00	1,969,914,800.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,969,914,800.00	1,969,914,800.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	202,723,400.00	202,723,400.00
132001	Орон нутгийн төсвөөс	202,723,400.00	202,723,400.00

1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	146,724.00	146,724.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	146,724.00	146,724.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	9,928,500.00	9,928,500.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,780,000.00	3,780,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	6,148,500.00	6,148,500.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	111.00	111.00
620001	Удирдах ажилтан	01.00	01.00
620002	Гүйцэтгэх ажилтан	67.00	67.00
620003	Үйлчлэх ажилтан	43.00	43.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Булган сумын 1-р сургууль нь 2021-2022 оны хичээлийн жилд “Хүүхдийн хөгжлийг дэмжсэн хичээл сургалтыг үр дүнтэй зохион байгуулж, өөрийн төлөвлөлттэй, бие даасан зөв хүүхэд төлөвшүүлнэ” гэсэн зорилготойгоор удирдах 1, бага ангийн багш 19, дунд ахлах ангийн багш 42, дотуур байрны багш 4, сургуулийн нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, сургалтын менежер нар 5, ажилтан 8, үйлчлэх 28, нийт 107 орон тоотойгоор сургалтын үйл ажиллагааг явуулсан байна.

Булган сумын 1-р сургуульд 44 бүлгийн 1173 суралцагч, үүнээс эрэгтэй 588, эмэгтэй 585, сурагчтай. 420 хүүхдийн багтаамжтай хичээлийн 1-р байранд 644 сурагч, 320 хүүхдийн багтаамж бүхий хичээлийн 2 дугаар байранд 529 хүүхэд, 80 хүүхдийн багтаамж бүхий дотуур байранд 130 хүүхэд, 18 га талбай бүхий хичээл туршлагын талбайтайгаар сургалт хүмүүжлийн үйл ажиллагааг 1, 2 дугаар ээлжээр явуулсан байна.

Нийт багш нараас 20 заах аргач, 28 тэргүүлэх багш мэргэжлийн зэрэгтэй, 8 магистрын зэрэгтэй, нийт багш нарын 86.4 хувь нь эрэгтэй багш нар ажилласан байна.

2021- 2022 оны хичээлийн жилд бага боловсролыг 118 сурагч, суурь боловсролыг 106 сурагч, бүрэн дунд боловсролыг 91 сурагч тус тус амжилттай суралцаж төгссөн байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллага нь үйл ажиллагаандаа Бага дунд боловсролын тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Татварын тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Тухайлбал:

- “Хувьсах зардлын дундаж норматив тогтоох тухай” Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоол;
- “Хичээл, сургалтын үйл ажиллагаа, Багшийн тасралтгүй хөгжил, цахим хэрэглээ, тоног төхөөрөмж нөхөн хангалт батлах тухай” Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны А/170 дугаар тушаал;
- “Ерөнхий боловсролын сургуульд кабинет, лаборатори, цахим сургалтын танхим байгуулах, ашиглах тухай журам” Боловсрол, шинжлэх ухааны сайдын А/465 дугаар тушаал;

- “Төрийн болон орон нутгийн өмчийн сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагааны гүйцэтгэлийн чанар үр дүнд үнэлж, үр дүнгийн урамшуулал олгох журам” Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны А/500 дугаар тушаал тус тус шинэчлэгдэн баталсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын ажилтан томилсон, дотоод хяналтын баг өдөр тутмын үйл ажиллагаандаа хяналт хэрэгжүүлж ажилладаг байна. Иймд дотоод хяналтын хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж дүгнэлээ.

Тайлант онд БШУЯ-ны дотоод аудитын алба болон аймгийн ЗДТГ-ын Санхүү, дотоод аудитын албанаас тус сургуулийн 2022 оны үйл ажиллагаанд хяналт шалгалт хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Тус сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж буй Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг 2017 онд баталсан бөгөөд шинээр батлагдсан холбогдох хууль, дүрэм, журам, заавар аргачлалын дагуу өөрчлөлтийг тусгасан байгаа нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Булган сумын сургуулийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүнд өмнөх оноос 43.7 сая төгрөгөөр буюу 1.4 хувиар өссөн байна. Өмнөх оноос мөнгөн хөрөнгөд өөрчлөлт ороогүй, авлага 13.9 сая төгрөгөөр буюу 100 хувиар буурсан, бараа материал 16.9 сая төгрөгөөр буюу 18 хувиар буурсан, үндсэн хөрөнгө 74.5 сая төгрөгөөр буюу 2.5 хувиар өссөн, өр төлбөр 8.1 сая төгрөгөөр буюу 78 хувиар өссөн, засгийн газрын хувь оролцоо 35.6 сая төгрөгөөр буюу 1.1 хувиар өссөн зэрэг өөрчлөлтүүд орсон байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	-	-	-
Бараа материал	87.80	70.90	(16.90)
Үндсэн хөрөнгө	3,022.20	3,096.70	74.50

Нийт хөрөнгө	3,123.90	3,167.60	43.70
Өр төлбөр	10.40	18.50	8.10
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	3,113.50	3,149.10	35.60
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	3,113.50	3,149.10	35.60

Дээрх хүснэгтээс харахад Булган сумын ЕБС-ийн 1-р сургуулийн 2022 оны жилийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 43.7 сая төгрөгөөр өссөний материаллаг нөлөө нь үндсэн хөрөнгийн данстай холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллага 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,861.8 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 202.7 сая төгрөг, үйл ажиллагааны орлогоос 0.6 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 9 хөтөлбөрийн 12 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,861.8 сая төгрөгийг улсын төсвөөс, 202.7 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 0.6 сая төгрөгийг үйл ажиллагааны орлогоос бүрдүүлэхээр баталжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,969.9 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 202.7 сая төгрөг, үйл ажиллагааны орлогоос 9.9 сая төгрөг, нийгмийн даатгалын сангаас 0.15 сая төгрөг, нийт 2,182.7 сая төгрөгийн санхүүжилтийг бүрдүүлж, орон нутгийн төсөвт 34.7 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,148.0 сая төгрөг буюу 109.5 хувьтай байгаа нь өмнөх оноос цалин хөлс нэмэгдэл урамшууллыг 93.6 сая төгрөгөөр, НДШ-ийн зардлыг 12.3 сая төгрөгөөр, бараа үйлчилгээний зардал 78.8 сая төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн бараа үйлчилгээний зардлыг 6.1 сая төгрөгөөр, бусад урсгал шилжүүлгийн зардлыг 15.4 сая төгрөгөөр тус тус илүү зарцуулж, байр ашиглалттай холбоотой зардал 12.8 сая төгрөгөөр, норматив зардал 6.5 сая төгрөгөөр тус тус буурсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

Код	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/сая төгрөг/	
				Зөрүү	Биелэлт
81834	Боловсролын стандарт, сургалт	1,406.10	1,406.10	0.00	100%
81835	Сургалтын хэвийн үйл ажиллагаа	211.30	211.30	0.00	100%
81806	Дотуур байрны үйлчилгээ	124.40	124.40	0.00	100%
80226	Байр ашиглалтын үйлчилгээ	5.70	5.60	0.10	98%
81801	үдийн цай хөтөлбөр	123.80	116.20	7.60	93%
81605	Эрүүл мэндийг дэмжих	6.60	6.60	0.00	100%
80312	Сургалт семинар	2.80	2.80	0.00	100%
81844	Гүнзгийрүүлсэн болон төрөлжсөн	3.09	3.09	0.00	100%

81848	Сурах бичгийн түрээс	6.10	6.10	0.00	100%
80111	Тогтмол зардал	99.20	86.40	12.80	85%
Нийт дүн			1,968.59	20.50	976%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Ховд аймгийн Булган сумын 1-р сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Эл Би Альфа Экспэйншин Аудит ХХК-ны аудитор Г. Баясгалан гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цэцэгсүрэн, дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар нар хэрэгжүүлсэн.

Ховд аймгийн Булган сумын 1-р сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 06 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Бага” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны нийт орлогын 1,959.2 сая төгрөгөөс 0.5 хувиар буюу 9.8 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн шатанд 2022 оны санхүүгийн тайлангийн нийт зардлын 2,148.0 сая төгрөгөөс 0.5 хувиар буюу 10.7 сая төгрөгөөр тогтоож, гүйцэтгэлийн материаллаг байдлыг 70 хувиар тооцон 7.5 сая төгрөгөөр дахин хянаж шинэчлэн тогтоосон болно.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага хуулиар хориглосон зардлуудыг санхүүжүүлээгүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим системд тендерт шалгарсан оролцогчийн мэдээлэл, таван саяас дээш орлого, зарлагын гүйлгээг бүрэн мэдээлж, төсвийн шууд захирагчийн төсөв өмч хөрөнгө мөнгө зарцуулах өр авлага үүсгэсэн шийдвэрийг огт мэдээлээгүй, тайлант хугацаанд оруулбал зохих 170 мэдээллээс хугацаандаа оруулсан 126, хугацаа хоцроосон мэдээлэл 43, огт мэдээлээгүй 1 байна.

4.5 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар “Зөрчилгүй” санал дүгнэлт авч нүүрс илүү нөөцөлсөн, 43-р тогтоолын дагуу 20.9 сая төгрөгийн төсвийн хэмнэлт хийгээгүй нийт 2 зөвлөмж авсан байна.

Хүснэгт 3. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Илрүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага					
Зөвлөмж	2	20.9	2	20.9	
Нийт дүн	2	20.9	2	20.9	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар төрийн хэмнэлтийн хуультай холбоотойгоор бензин түлшийг үр ашиггүй шаардлагагүй үйл ажиллагаанд зарцуулсан эсэх дээр анхаарч шалгах шаардлагатай.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1.1 сая төгрөгийн зөрчил илэрснээс, 1.1 сая төгрөгийн 1 албан шаардлага хүргүүлсэн.

5.1 Албан шаардлага

5.2.1 Төсвийг үр ашигтай зарцуулах, шатахууны зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Байгууллагын бараа материалын тайланд 1.1 сая төгрөгийн 292 литр шатахуун орлого авч сурагчдын тэмцээн, уралдаанд явах машинд гарган өгч төсвийг үрэлгэн зарцуулсан байна. Шатахуун зарцуулалтын тайлан, замын хуудас, талоны бичилтээс үзэхэд тухайн шатахууныг зайлшгүй шаардлагатай биш ажил үйлчилгээнд зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6-р зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” Төсвийн тухай хуулийн 5-р зүйлийн 5.1.2-д “Төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх”, 16-р зүйлийн 16.5.6-д “Дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх” гэсэн заалттай нийцэхгүй байна.

6. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

Зөрчлийн товч утга	Үүнээс							
	Нийт алдаа		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Төсвийг үр ашигтай зарцуулах, шатахууны зардалтай холбоотой асуудал	1	1.1	1	1.1				
Дүн	1	1.1	1	1.1				

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

X. Болдбаатар Х. БОЛДБААТАР

АУДИТЫН МЕНЕЖЕР:

А. Цэцэгсүрэн А. ЦЭЦЭГСҮРЭН

ТАЙЛАНГ БИЧСЭН

ЭЛ БИ АЛЬФА ЭКСПЭЙНШИН АУДИТ ХХК- ний

АУДИТОР:

Г. Баясгалан Г. БАЯСГАЛАН

